

Харилцах

Герман Улсад



Др. Алфред Катер

Төслийн зохицуулагч
ИАК АГРАР КОНСАЛТИНГ
ХХК
Борнауер гудамж 16
04288 Лайпциг
Утас: +49 34297 71425
Факс: +49 34297 42809
И-мэйл: a.kather@iagleipzig.de
Вэб: www.iagleipzig.de

Монгол Улсад



Ханс-Юрген Фүллэ

Төслийн Удирдагч
ИАК АГРАР КОНСАЛТИНГ
ХХК
Утас: +976 99673646
+976 88098025
И-мэйл: fuelle@iagleipzig.de
Вэб: www.dmkn.de



Эрхлэн гаргасан

Эрхлэн гаргасан

Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам
Bundesministerium für Ernährung und Landwirtschaft (BMEL)
Wilhelmstraße 54
10117 Berlin

ГФА Консалтинг групп ХХК
GFA Consulting Group GmbH
Wallstraße 15
10179 Berlin

Хэвлэсэн огноо

2015 оны гуравдугаар сар

Текст

ИАК АГРАР КОНСАЛТИНГ ХХК

Эх бэлтгэл

design. idee, büro_für_gestaltung, Эрфурт

Гэрэл зураг

ИАК АГРАР КОНСАЛТИНГ ХХК

Хэвлэл

ХХХААЯ

Энэхүү төсөл нь (төслийн дугаар: MNG 13-01)
Холбооны Хүнс хөдөө аж ахуйн яамны санхүүжилтээр
ГФА Консалтинг Групп ХХК-аар дамжуулан хэрэгжиж
байна.



Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи хаягнаас авна уу
www.bmel-kooperationsprogramm.de
www.dmkn.de



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



Монгол Улс дахь Хөдөө аж
ахуйн тогтвортой хөгжил

ХБНГУ болон Монгол Улсын хамтарсан төсөл



Төслийн тухай

Монгол Улс нь 1,56 сая км нутаг дэвсгэртэй, 2,73 сая хүн амтай хүн амын нягтралаараа хамгийн сийрэгт ордог дэлхийн улс орны нэг юм. Тус улсын хувьд хөдөө аж ахуйн нь эдийн засгийн тулгуур салбар бөгөөд цаашид ч өргөжиж, бүтээгдэхүүнээ экспортлох боломж ихтэй салбар юм. Ажил эрхлэгчдийн нийт 38% нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

Нийт нутаг дэвсгэрийн 114 сая га талбайд газар тариалан эрхлэх боломжтой бөгөөд үүний 90% нь ойт хээр, бэлчээрийн бүс нутаг, 835.000 га тариан талбай тус тус эзэлнэ. Монгол Улсын газар тариалангийн гол бүс нутаг нь нутгийн хойд хэсэг болон тал хээрийн бүс юм. Монголд гол төлөв үр тариа, улаан буудай, рапс, төмс хүнсний ногоо тариалдаг.

Герман-Монголын хамтарсан “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл 2013 оны 4-р сараас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд төслийн зорилго нь Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын нөөц бололцоог түлхүү ашиглахад өөрсдийн хувь нэмрээ оруулахад оршино.



Төслийн зорилго ба хамрах хүрээ



Төслийн хүрээнд хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудыг мэдээллийн олон талт үйл ажиллагаа, сургалтуудад оролцуулах замаар онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх боломжийг олгоно. Сургалтын агуулга нь төмс, үр тариа тариалах орчин үеийн дэвшилтэт аргачлал болон менежментийн аргуудад чиглэгдэх юм.

Энэхүү төслийг загвар болохоор сонгосон хоёр аж ахуйтай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд дээрх 2 аж ахуй нь орчин үеийн, өөрийн орны нөхцөлд тохирсон тариалалтын арга туршлагуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх юм.

Судалгаа шинжилгээний ажил болон Улаанбаатар хотод зохион байгуулах онолын сургалтуудыг Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран зохион байгуулж байна.

Төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд:

- Практикт ойр нөхцөлд тогтвортой газар тариалалтын системийг хөгжүүлэх, нутагшуулах
- Хөдөө аж ахуйн салбарын удирдах болон техник мэргэжлийн ажиллагсдын хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтууд зохион байгуулах
- Газар тариалангийн тодорхой сэдвүүдээр бодлогын зөвлөгөө өгөх
- Мэдээллийн болон олон нийтэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах юм.

Хамтран ажиллаж байгаа байгууллагууд

Төслийг дэмжигч нь Холбооны Хүнс хөдөө аж ахуйн яам ба гол түншлэгч нь Монгол Улсын Үйлдвэр хөдөө аж ахуйн яам юм.

Төслийг ИАК АГРАР КОНСАЛТИНГ ХХК-ийн удирдлагаар АФС Консультантс Интернэйшнл ХХК, ДОЙЛА Нийнбург ХХК, ДЛЖ Интернэйшнл ХХК зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна.

Төслийг хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмж, ургамал хамгаалал болон үр сорт, агрохимийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд орчин үеийн дэвшилтэт техник технологээр ханган, мэргэжлийн зөвлөгөө өгч дэмжин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар дараахь компаниуд төсөлд оролцож байна:

